



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/694

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хөөмийг Генниссийн амжилтанд бүртгүүлэх арга хэмжээнд оролцож буй алдар цолтой, ахмад хөөмийч уран бүтээлчдэд хүндэтгэл үзүүлэх нэрс, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 1 050 000 төгрөг /Нэг сая тавин мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 28 -ны өдрийн А/ 694 дүгээр захирамжийн хавсралт



ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ АХМАД ХӨӨМИЙЧДИЙН НЭРС

Д.д	Цол зэрэг	Овог нэрс
1	МУГЖ нэрт хөөмийч	Н.Сэнгэдорж
2	МУГЖ нэрт хөөмийч	Б.Одсүрэн
3	МУГЖ нэрт хөөмийч	Д.Цэрэндаваа
4	Хамгийн ахмад 83 настай хөөмийч	Ц.Төрбат
5	МУСТА, ахмад хөөмийч	Д.Жаргал
6	МУСТА, ахмад хөөмийч	С.Минжээсүрэн
7	МУСТА, ахмад хөөмийч	Р.Даваажав

ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д.д	Зардлын төрөл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1	Гарын бэлэг /Дээлийн торго 4м, эмжээр, сүү 1л, чихэр 1кг, хайрцагтай печень/	Ш	7	50.000	350.0
2	Дагалдан олгох мөнгөн шагнал	Ш	7	100.000	700.0
	НИЙТ ДҮН				1 050.0

-oOo-